



**“ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН 2018-2019 ОНЫ
ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН”**

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч.ДОРЖПАГМА

1. НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын ЕБС-ийн дэргэдэх Насан туршийн боловсролын нэгж нь сургуулийн хичээлийн А байранд ажил үйлчилгээгээ явуулж байна. Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд суурин компьютер-1, проектор-1, принтер-1, сандал-10ш, дохионы хэлний зурагт толь бичиг 1, 15 төрлийн ном, гарын авлагатайгаар сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Зорилго:

Сумын иргэдийн боловсролын хэрэгцээнд тулгуурлаж Насан туршийн боловсролын 5-н чиглэлийн сургалт болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх.

Зорилт:

1. Иргэдийн боловсролын хэрэгцээний судалгаа хийх
2. Сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах
3. Сургууль завсардсан хүүхэд залууст боловсрол нөхөн олгох
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг боловсролд тэгш хамруулах, амьдрах ухаанд сургах
5. Иргэдэд тасралтгүй суралцах орчин нөхцөл бүрдүүлэх
6. Төрийн болон ТББ, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах

Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалт

2018-2019 оны хичээлийн жилд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд суурь боловсрол эзэмших 4 суралцагч, бүрэн дунд боловсрол эзэмших 4 нийт 8-н суралцагч бүртгэгдэн танхимын, зайны, гэрийн буюу шавь сургалт, түр цугларалт, бие даах гэсэн сургалтын хэлбэрүүдээр суралцаж байна.



Насан туршийн боловсролын 5 чиглэлийн сургалт хийсэн байдал



Гэр бүлийн
боловсрол



Иргэний
боловсрол



Ёс суртахууны
боловсрол



Гоо зүйн
боловсрол



Амьдрах ухааны
боловсрол



“Амьдрах ухааны боловсрол хүрээнд”

1. Бичиг үсгийн боловсролын сургалт

Бичиг үсгийн боловсрол эзэмших хүсэлтэй иргэн Ж. Ганцолмонтой 2019 оны 02-сарын 11-ээс 3 сарын 20 хүртэл ажиллахдаа дараах мэдлэгийг олгосон байна. Үүнд:

Монгол хэлний хичээлээр

- Эгшигт долоо гийгүүлэгч, заримдаг есөн гийгүүлэгч, хатуу зөөлний тэмдэг, эр эм үгийн ы зэрэг үгийг зөв цэвэр бичиж, богино үгийг, үеэр холбож уншуулж сургалаа.

Давуу тал

- Монгол хэлний сургалтын агууллагаас цэвэр бичих чадварыг илүү сайн эзэмшсэн.

Сул тал

- Үсэг нүдлэх урт үг холбож уншиж чадвар сул байлаа.



Тооны хичээлээр

- 1-ээс 20 хүртэл тоолж сурсан ба 20-ын дотор тоог нэмж хасаж сурсан.

2. Цаасан урлалын сургалт

Хүүхдийг цаасаар урлан бүтээх чадварт сургаж, хүүхдийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, мэдлэгээ бүтээлчээр ашиглах бүтээлч хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 12, 1, 2 саруудад 4,5-р ангий сурагчдад цаасан урлалын сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд сурагчид цаасар олон төрлийн зүйл хийж амьдрал ахиудаа хэрэглэх чадвартай болсон.





. Ёс суртахуун-төлөвшлийн боловсролын хүрээнд

1. “Эерэг сэтгэлгээг хөгжүүлэе” сэдэвт сургалт

Сурагчдыг амьдралаас авч буй мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж, сөрөг мэдээллээс татгалзаж, эерэг сэтгэлгээгээр аливаа зүйлийн сайн сайхан талыг олж харж чаддаг, аливаа тулгарсан саад бэрхшээлийг өөдрөгөөр даван туулах чадвартай болгох зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 12-16 нд 6-8-р ангийн сурагчдад “Эерэг сэтгэлгээг хөгжүүлэе” сэдэвт сургалт хийсэн. Сургалтыг анги ангид нь орсон бөгөөд сургалтын явцад хүүхдүүд маш их идэвхтэй оролцсон. Сургалтын үр дүнд сурагчид амьдралаас авч буй мэдээлэлдээ дүн шинжилгээ хийдэг болж, сөрөг мэдээллээс татгалзаж, эерэг сэтгэлгээгээр аливаа зүйлийн сайн сайхан талыг олж харж чаддаг, аливаа тулгарсан саад бэрхшээлийг өөдрөгөөр даван туулах чадвар, хандлагатай болсон. Сургалтанд нийт 125 сурагчид хамрагдсан.



2. 2018 оны 12 сарын 1 нд ОУ-ын “ДОХ-той тэмцэх” дэлхийн өдрөөр сурагчид, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн мэдлэг, зөв дадал олгох зорилгоор ЕБС-ийн 8-11-р ангийн сурагчдын дунд “Эрүүл залуус-Эрүүл ирээдүй” сэдэвт “Дэвжээ” тэмцээнийг сургуулийн эмчтэй хамтран зохион явуулсан. Сурагчид энэхүү тэмцээнээр БЗДХ/ХДХВ/ДОХ/-оос урьдчилан сэргийлэх арга, сайн дурын шинжилгээ өгч, зөвлөгөө авахын ач холбогдлыг ойлгож авсан. Нийт 50 сурагч оролцсон.


3. Эцэг эхчүүдийн дунд БЗДХ/ХДХВ/ДОХ/-оос урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн мэдлэг, зөв дадал олгох зорилгоор сургуулийн эмчтэй хамтран “АХА” тэмцээн зохион байгуулсан. Нийт 35 эцэг эх оролцсон.



4. Чандмань-өндөр сумын иргэд, эцэг эхчүүдэд 04-р сарын 30-ний 14 цагт Соёлын төвд “Хүн байхын учир”, “Цахим орчны зөв хэрэглээ,” сургалтыг зохион байгууллаа. Энэхүү 2 сургалтаар иргэдэд цахим орчинг хэрхэн зөв ашиглах, цахим гэмт хэргээс хүүхдийг хэрхэн хамгаалах мөн хүүхдийн суурь хүмүүжил төлөвшлийг зөв, тэгш тавих талаар мэдлэг олголоо. Сургалтанд 30 эцэг эх оролцлоо.



5. 2019 оны 5 сард Дотуур байрны 50 сурагцагчдад өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх өөрсдийгөө бусдад зөвөөр илэрхийлж бусдад эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор "Өөртөө итгэх итгэл түүнийг тодорхойлох нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтаар сурагчид өөрсдийн өмнө тулгамдаж буй асуудлыг нээлттэй хэлэлцэж өөрсдийн бодол санаагаа бусадтай хуваалцаж өөрийгөө бусдад зөвөөр илэрхийлэх чадварт суралцсан юм.



6. 2019 оны 05-р сарын 01 нд Тосонцэнгэл сумын НТБ-ын багш П. Сарантуяа “Жаргалан” цэцэрлэгийн 18-н багш, ажилчидад “Хүнээр хүн хийх нь” сургалтыг орлоо. Энэхүү сургалтаар хүүхдийн суурь хүмүүжил төлөвшлийг зөв, тэгш тавих талаар мэдлэг ойлголтыг өгч мэдээлэл хийлээ.



7. 2019 оны 5 сард ЕБС-ийн ажилчдад “Стресс түүнийг зохицуулах нь” сэдвээр сургуулийн А байрны 101 танхимд сургалт орлоо. Сургалтын хугацаанд ажилчдад дадлага ажил хийлгэж богино болон урт хугацааны стресс үүсэх нөхцөл байдлыг тодорхойлуулан, стресс хүний бие махбод, сэтгэл хөдлөл, зан үйлд үзүүлэх нөлөөг нэрлүүлж, стрессийг тайлах аргуудаа хамтран ярилцаж стрессээ тайлах эерэг арга чадвар эзэмшлээ.



8. 2019 оны 05-р сарын 02 нд Соёлын төвд 20-н төрийн албан хаагчдад П. Сарантуяа багш “ Биеэ хүний соёл”, “Хүнээр хүн хийхийн учир нь” лекц уншлаа. Лекцээр бие хүний биеэ авч явах соёл, харилцаан зөв дадал, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар мэдээлэл олголоо.



9. Мөрөн сумын НТБ-ын төвийн Дүйцсэн хөтөлбөрийн бага, суурь боловсролын 22-н суралцагчдад “Цахим орчинд өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?” сургалтыг орж энэхүү сургалтаар хүүхдүүд цахим орчинг зөв ашиглах, цахим гэмт хэргээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэг ойлголттой боллоо.



Иргэний боловсрол /экологи, эдийн засаг, улс төр, эрх зүй/ олгох сургалтын хүрээнд

1. Тогтвортой хөгжлийн боловсрол

2018 оны 12 сард 9-11-р ангийн сурагчдад Эх орон байгаль дэлхийгээ хайрладаг, экологийн тэнцвэрт байдлыг бий болгох, хадгалахад өөрийн хувь нэмрийг оруулахуйц мэдлэг, чадвар, ёс суртахууны хүмүүжилтэй болгох зорилгоор “Хүмүүний экологийн ул мөр” сэдэвт сургалт хийсэн. Сургалтанд ахлах ангийн 9-11-р ангийн 56 сурагчид хамрагдсан. Сургалтаар хогийг жижигрүүлж хаях болон байгаль дэлхийг хайрлах зөв хандлагад суралцлаа.



“Хуримтлалын бүлэг хэрхэн байгуулах вэ?” /сургалт/

2. Боловсрол, соёл, урлагийн газрын 2018-2019 оны хичээлийн жилийн зорилтод “Суралцагчдад хэрэглээг бус хуримтлуулдаг сэтгэлгээг төлөвшүүлнэ” гэж тусгасны дагуу 2019 оны 3 сарын 18 нд суралцагчдын дунд Хуримтлалын бүлэг байгуулах талаар сургалт орж үүний үр дүнд сурагчид хуримтлалын бүлэг байгуулах мэдлэг, мэдээлэлтэй болж 2019 оны 3 сарын 19 нд 7а ангийн сурагчид “ Ирээдүйн санхүүчид” нэртэй хуримтлалын бүлэг байгууллаа.



3. 2019 оны 05 сарын 01 нд Сумын ЭМТ-ийн 10 хэвтэн эмчлүүлэгчдэд “ Хэрэглэгчдийн эрх, эмийн зохистой хэрэглээ”, “Хуванцар сав түүний хор уршиг” гэсэн 2 сургалтуудыг хийлээ. Энэхүү сургалтаар хүмүүс хуурамч эм, хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн таних, хуванцар савны тэмдэглэгээ, химийн хорт бодис агуулдаг савыг таних мэдлэг ойлголттой боллоо.



4. 2019 оны 05 сарын 06 нд Мөрөн сумын НТБ-ын төвийн багш нартай хамтарч аймгийн Онцгой байдлын газартай хамтран олон нийтийн оролцоотой Гамшгийн эрсдлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр иргэдэд мэдлэг олгох зорилгоор “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 14 багийн 60 иргэдэд хийлээ.

Сургалтаас иргэд гамшиг болон аюулт үзэгдэл, эмзэг байдлын талаар мэдлэг ойлголттой болж болзошгүй аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, түүнийг хохирол багатай даван туулах мэдлэгт суралцлаа.



Гоо зүйн боловсрол олгох сургалтын хүрээнд

- 2019 оны 04 дугаар сарын 24 нд ЕБС-ийн дотуур байрны ахлах ангийн 20 эмэгтэй сурагчдад өөртөө итгэлтэй, өөрийн гадаад гоо үзэсгэлэнгээ зөв авч явахад сургах, гоо сайхан, гоо зүйн хүмүүжил олгох зорилгоор Үсээ олон төрлөөр сүлжих, хүзүүний ороолтыг олон төрлөөр ороох болон хувцасаа зөв эвхэх сургалтыг хийсэн.



Үс олон төрлөөр сүлжих сургалт



Хүзүүний ороолтоо олон төрлөөр
ороох сургалт



Хувцасаа зөв эвхэх сургалт



Шинжлэх ухаан сургалт

БСШУС-ын сайдын 2018 оны 03-р сарын 29-ний өдрийн А/155 тоот тушаалыг хэрэгжүүлэх, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор 10-р сарын 27-нд Чандмань-өндөр сумын ЕБС-ийнхаа багш нарт “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах арга зүйн” сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд нийт 36 багш суусан. Сургалтаар багш бүрт ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар тарааж өгч ажиллуулсан.

Сургалтын үр дүнд бүх судлагдахууны багш нар Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах арга зүйн мэдлэг, чадвар эзэмшсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд дэмжлэг үзүүлж ажилласан байдал:

1. II улиралд Хөгжлийн бэрхшээлтэй 2-р ангийн сурагч Э. Дэлгэрмөрөнг монгол хэлний 35 үсгийг нүдлэх, холбож уншиж сурах, мөн 20 дотор тоо бодож сурахад нь дэмжлэг үзүүлж ангийн багштай нь хамтарч ажилласан.



2. 2018 оны 12 сарын 18 нд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн Шинэ жилийн үйл ажиллагааг Сургуулийн эмч Н.Энхцэцэг МХУЗ-ын багш П.Отгонбаяр багштай хамтран тэмдэглэн өнгөрүүлээ.

Энэхүү үйл ажиллагааны зорилго нь ХБХ-ийг судлан оношилж, тэдгээрийг сурах нөхцлөөр хангаж, авьяас чадварыг хөгжүүлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн юм. Энэхүү үйл ажиллагаагаар суралцагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэдээлэл өгч бие эрхтэнг сайжруулах дасгал хөдөлгөөн зааж, хүүхдүүдийг халуун аарцаар дайлж, өвгөн аавын бэлэг өгч, эмзэг бүлгийн хүүхдүүдэд өвлийн куртик өгч дэмжлэг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй 37 хүүхэд оролцсон.



3. 2018 оны 03 сарын 18 нд Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдийг /хөгжлийн бэрхшээлтэй, сурлагаар хоцрогдсон, ар гэрийн асуудалтай гм/ боловсролд тэгш хамруулах зорилгоор “Сургуулийн дэмжлэгийн зөвлөл байгуулсан.

Энэхүү дэмжлэгийн зөвлөлийн ажил үүрэг нь:

- Дэмжлэг хэрэгцээтэй хүүхдийг тодорхойлох
- Бодит байдлын судалгаа хийх
- Хүүхэд бүр дээр шаардлагатай дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах
- Төлөвлөгөөний хэрэгжилтэнд мониторинг хийх
- Шаардлагатай үед мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах
- Багш нарын сургалт, эцэг эх орон нутгийнханд хандсан сургалт зохион байгуулах

Судалгааны ажлууд


1. Хамран сургах тойргийн сургуулийн насны хүүхдийн тоо, судалгааг багийн дарга нартай хамтарч 11 сард гаргасан. Энэхүү судалгаагаар сурагчдын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, сургууль завсардсан хүүхдүүдийг илрүүлсэн.
2. Иргэдийн боловсролын хэрэгцээний судалгаа
 - Иргэдийн боловсролын хэрэгцээг судалж, түүнд тулгуурласан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор 5-н багийн иргэдийг хамарсан нийт 150 иргэнээс “Иргэдийн боловсролын хэрэгцээний судалгаа” авч үр дүнг боловсруулж нэгтгэн ажилдаа тусган хэрэгжүүлж байна. Энэхүү иргэдийн боловсролын хэрэгцээний судалгааг 11 сарын 05 наас эхлэн 11 сарын 23 хүртэл авсан бөгөөд судалгааг авахдаа Чандмань өндөр сумын 5-н багийн иргэдийг тэгш хамруулах үүднээс банк болон үйлчилгээий бусад байгууллагуудад үйлчлүүлж буй иргэдээс судалгааг авсан. Судалгаанд хүйсийн хувьд эрэгтэй 74 эмэгтэй 76 хүн оролцсон.

Насан туршийн боловсролын 5-н чиглэлийн хүрээний дэд асуулгуудаас иргэдийн боловсролд хамгийн их хэрэгцээтэй байгаа сургалтуудыг дурдвал:

- Хууль эрх зүйн талаарх мэдлэг
- Эрүүл мэнд, эрүүл ахуй, эрүүл хоол хүнс
- Бизнес эрхлэх
- Гэр бүлийн тулгамдсан асуудлаа зохистойгоор шийдвэрлэх
- Үр хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх
- Гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэх, сонгох
- Ардын уламжлалт өв соёлоосоо суралцах,
- Өөртөө итгэх итгэл, өөрийн үзэл бодлоо илэрхийлэх
- Харилцаа холбоо, харилцах ур чадвараа дээшлүүлэх
- Өрхийн төсөв, санхүү зарцуулалт
- Оёдол нэхмэл хатгамал хийх
- Хүнсний ногоо тариалах, даршлах

3. Багшийн боловсролын хэрэгцээний судалгаа

- Багш нарын ажлын байрандаа тасралтгүй хөгжиж, суралцах хэрэгцээг тандах, судалгаагаар эрэмбэлэгдсэн чиглэлийн хүрээнд хамгийн ойр, мэдлэг чадвар бүхий сургагч багшаар дамжуулан тэдний хөгжилд дэмжлэг болох сургалт зохион байгуулах зорилгоор сургуулийн 36-н багшаас Багшийн боловсролын хэрэгцээний судалгааг 11 сард авч үр дүнг боловсруулсан.



4. 2018 оны 10-р сарын 19-23 өдрүүдэд Сумын засаг даргын захирамжийн дагуу “Хүүхэд хамгаалал, өрхийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж сумын 4-р багийн 50 өрхөөр явж судалгаа хийсэн.

5. ЕБС-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа /30 сурагч ХБ/

6. Сургуулийн ундны усны орчинг үнэлэх судалгаа

7. Сумын бичиг үсэг үл мэдэгч иргэдийн судалгаа /19 иргэн бичиг үсэг үл мэдэгч/

8. Сумын хэвтэрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа /5 хүүхэд/

9. “Хөгжлийн давуу чанарын үзүүлэлтийн судалгаа /12-18 өсвөр насны хамрагдсан /

Бүтээлч ажил

Багш нар хичээл сургалтандаа ашиглах боломжтой “Сургалтын үнэлгээний олон хувилбарууд” гарын авлага гаргасан.

ДҮГНЭЛТ

Ийнхүү 2018-2019 оны хичээлийн жилийн хугацаанд амьдрах ухааны боловсролын сургалт 2, ёс суртахууны төлөвшлийн сургалт 9, иргэний боловсролын сургалт 5, гоо зүйн боловсролын сургалт 3, шинжлэх ухааны сургалт 1-ийг хийсэн бөгөөд нийт 20-н сургалт хийсэн байна. Эдгээр сургалтуудад нийт 612 хүн хамрагдсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд чиглэсэн 3 ажил 9 төрлийн судалгааны ажил хийж НТБ гадна доторхи кабинетийг шинэчилсэн. Цаашид иргэдрүү чиглэсэн тэдний хэрэгцээнд нийцсэн амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулахад анхаарч ажиллахаар төлөвлөөд байна.

Анхаарал хандуулсан та
бүхэнд баярлалаа.